

ТОВЪЁГ

НЭГ. Тайлант жилд дэвшүүлсэн бодлогын зорилт, стратеги.....	1-5
ХОЁР. Эрхлэх үйл ажиллагааны мэдээлэл.....	5-6
ГУРАВ. Нийгмийн даатгалын сангийн зардлын тайлан.....	6-11
ДӨРӨВ. Архив, албан хэрэг хөтлөлт.....	11-15
ТАВ. Хяналт, шалгалт дотоод аудитын үйл ажиллагаа.....	15-26
ЗУРГАА. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт.....	26-31
ДОЛОО. Санхүүгийн үйл ажиллагаа.....	31-34

НЭГ. ТАЙЛАНТ ЖИЛД ДЭВШҮҮЛСЭН БОДЛОГЫН ЗОРИЛТ, СТРАТЕГИ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын болон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2023 оны жилд хөгжүүлэх үндсэн чиглэл, УИХ, Засгийн газар, аймгийн ИТХ-аас батлан гаргасан үндэсний болон дэд хөтөлбөр, Засгийн газрын болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас батлан гаргасан тогтоол шийдвэр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэн ажиллав. Энэ жилийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын хэлтсийн 2020-2024 оны хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүнд үндэслэн хэлтсийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж доорх зорилгыг төлөвлөв. Үүнд:

- ✓ *Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах*
- ✓ *Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах*
- ✓ *Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”*

- ✓ Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах
- ✓ Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг, хөдөлмөрийн магадлах чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ажил олгогч, даатгуулагч, иргэн болон орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах
- ✓ Хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, дүгнэлт гаргаж үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн 8 үндсэн стратегийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор олон улсын чанарын удирдлагын болон дотоод аудитын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын менежмент, сайн засаглалд нийцсэн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, төрийн үйлчилгээний сайжруулалтын төсөл хөтөлбөрүүдийг нэвтрүүлэн чиглүүлж, судалгаа шинжилгээний дүгнэлтээр үр дүн, үр нөлөөг тооцож, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж ажиллалаа.

Мөн Нийгмийн даатгалын хэлтэс нь ISO 9001:2015 стандартыг 2024 оны 11 дүгээр сар хүртэл дахин сунгалт хийлгэж гэрчилгээ гардан аваад байна.

Төр засгийн болон аймаг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлтийн холбогдох зорилтыг тайлангийн хугацаанд хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлж чанаржуулах, хөгжлийн бодлогын хурдасгуур бий болгох, нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай, чанарын түвшинг ахиулах зорилгоор доорх бодлого дэвшүүлж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын байгууллагад олон улсын стандартууд нэвтрүүлэх, нийгмийн маркетингийг хөгжүүлэх, нэгдсэн бүртгэлийн систем бий болгох, роботын автоматжуулалтыг хөгжүүлэх, архивын бүртгэл, хадгалалт хамгаалалтыг автоматжуулах улмаар бүтээмжийг нэмэгдүүлэх, процессын дахин инженерчлэлийг тогтмол хийх замаар мэдээллийн технологи, техникийн дэвшилтэй уялдуулан автоматжуулалт, хиймэл оюун ухаанд суурилсан Цахим засаглалын суурийг тавьснаар Нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээг нэг байцаагчаас шат дамжлагагүй авах боломжийг бүрдүүлж хэвшүүллээ. Ингэснээр иргэн төвтэй Төрийн байгууллагын ил тод байдал, бүтээмжийг

дээшлүүлэн инновацийн бодлогыг стратегийн түвшинд үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр төрийн үйлчилгээний шат дамжлагыг халлаа.

Энэхүү ажлын хүрээнд өөрсдийн санаачлагаар дараах шинэлэг, инновац бүхий төсөл, хөтөлбөр үйл ажиллагаануудыг энэ оны гол зорилт болгон амжилттай хэрэгжүүллээ. Тус хэлтэс нь стратегийн зорилтын хүрээнд:

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний байгууллагын дотоод процесс үйл ажиллагааг цахим хэлбэрт оруулах, хийгдсэн ажил бүрийн нэгдсэн бүртгэлийн системийг бий болгох, CRM буюу байгууллагын иргэдэд чиглэсэн цахим системүүдийг бий болгоход чиглэсэн цогц програм хангамж болон технологийн дэмшилтэд шийдлүүдийг хамруулсан цогц төсөл хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласантай уялдуулан Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 5 зорилт 34 арга хэмжээ төлөвлөн ажиллаж 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.

Мөн тус хэлтэс нь Нийгмийн даатгалын байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийг эрсдлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, төрийн байгууллагад авлига бий болох шалтгаан нөхцөлийг арилгах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг чангатгах, шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор олон улсын ISO 37001:2016 стандартад нийцсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг 2022 оноос эхлэн үе шаттайгаар, холбогдох стандартаар тогтоосон шаардлагын дагуу нэвтрүүлэн ажиллаж Монгол Улсын Төрийн байгууллага дундаа анх удаа хэрэгжүүлж 2023 онд Авлигын эсрэг ISO 37001:2016 стандартад нэвтрүүлж БНЭУ-ын олон улсын баталгаажуулалтын QFC байгууллагын батламж гэрчилгээг БНЭУ-ын Элчин сайдаас гардан авсан юм.

Авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой нийт 16 сурталчилгааны постер бэлтгэж, хөлтэй самбарт хийж, байцаагч ажилчдын ширээн дээр байрлуулах, хэлтсийн албаны вэб хуудас болон пэйж хаягт байрлуулан ажиллаж авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулахаас гадна хэлтсийн 75776699 дугаарт залгаж, * хэсгээр холбогдох боломжтой болгож, сурталчлан таниулах постерууд бэлтгэж ажиллалаа. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг

нэмэгдүүлэх зорилгоор Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн албаны пэйж хуудас болон вэб хуудсанд хавсралт 1-ийн постеруудыг байрлуулан нийт 181 хандалт хүлээн авсан байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн 1 давхарт Хаан банкны АТМ машины хажууд иргэд ихээр үйлчлүүлдэг газар АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Мөн авлигын эсрэг стандартын дагалдах журмуудыг боловсруулан баталж хэлтсийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХОЁР. ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, даатгуулагч нарт үзүүлэх үйлчилгээг хуулийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын байгууллагаас үзүүлэх бүх төрлийн үйлчилгээг олон шат дамжлагагүй нэг дороос шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор үйлчилгээний нэг цэгийг 2018 оноос эхлүүлэн ажилуулж, үйлчилгээний шинэ арга барил, санаачлагыг нэвтрүүлэн, хөгжүүлэн ажиллаж байна. 2024 оны орон нутгийн төсөвт нийгмийн даатгалын ач холбогдлын сурталчилан таниулах, нийгмийн маркетинг хийх гэрээт ажилтаны цалингийн төсөвт санал хүргүүлэн 85 сая төгрөг батлууллаа.

2023 онд давхардсан тоогоор **29672** даатгуулагчид нийгмийн даатгалын сангийн үйлчилгээг үзүүлж, 166.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж төлбөрийг олгосон байна.

Малчин- даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох ажлын хүрээнд

Хяналт, шалгалт дотоод аудитын тасгийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хэлтсийн даргаар батлуулсан Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн 2023 онд дотооддоо хийх хяналт шалгалтын төлөвлөгөөнд заасны дагуу удирдамж №5 боловсруулан 2020-2022 оны хооронд хугацааны Баян-Өндөр сумын 22 иргэний, 2018-2022 оны Жаргалант сумын 3 иргэний нийт 25 тогтоолын үндэслэлийг шалгаж гарын үсэг, хавсралт баримт дутуу байсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч нотлох баримтын шаардлага хангахгүй байгаа 8 иргэний баримтын зөрчлийг арилгах зөвлөмж тайланг хугацаандаа гарган хүргүүлж 90,9% үр дүнтэй, хэрэгжилтийг 100% ханган ажилласан.

Мөн үйлчилгээний болон ХШДАТасгийн байцаагч нар 2020-2023 онуудад малчны нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын материалын үндэслэлийг шалгаж, АЖТДШНТТ хуулийн үйлчлэлд хамрагдаж жил нөхсөн 113 малчин-тэтгэвэр авагчийн жил нөхүүлэхдээ бүрдүүлсэн баримтын үндэслэлийг тэтгэврийн хувийн хэрэгт хавсарган ажиллав.

[Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилт:](#)

Төрөөс үнэт цаасыг мөнгөжүүлэх, өвлүүлэх ажлын хүрээнд тайлант хугацаанд өв үүссэн 4 хүний хүсэлтийг хүлээн авч НДЕГ-т хүргүүлж ажилласан. Үнэт цаас олгогдсон өв үүсээгүй үлдсэн иргэдийн ар гэрийнхэнтэй холбогдох талаар багуудын ажилтантай хамтран ажиллаж байна.

ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

3.1 ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН




Тайлант хугацаанд НДСОТТ-ийн тухай хуулийн хүрээнд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа 17.4 мянга тэтгэвэр авагчид, ЦАХТТ-ийн тухай хуулийн хүрээнд 681 алба хаагчид нийтдээ 67.8 тэрбум төгрөгийн тэтгэврийг сар бүр хуулийн хугацаанд олгосон.

3.1.1 Шинээр тогтоосон тэтгэвэр

Тайлант хугацаанд 1289 иргэнд шинээр тэтгэвэр тогтоосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 тэтгэвэр авагчаар буюу 0.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өнгөрсөн онуудад шинээр тогтоох тэтгэврийн тоо тогтворжих хандлагатай байсан бол энэ оны хагас жилийн байдлаар буурсан байна. Энэ нь Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилт болон тэтгэвэр тогтоох дараалласан 7 жилийн цалингийн өөрчлөлттэй холбоотой болов уу гэсэн таамаг байна. Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа 16.9 мянган тэтгэвэр авагчид нийт 67.9 тэрбум төгрөг олгосон нь батлагдсан төсвийн 98.3 хувийг зарцуулсан байна.

График 1. Шинээр тогтоосон тэтгэвэр



. Шинээр тогтоогдож байгаа тэтгэврийн дундаж дүн 831.7 мянган төгрөг байгаа нь 2022 оны шинээр тогтоосон дундаж тэтгэвэр /667.7 мянга/-ээс 24.6 хувиар өссөн байна.

3.1.2 Тэтгэвэр авагчийн банк сонголтын мэдээлэл

Шинээр тэтгэвэр тогтоолгосон 1289 иргэн үйлчлүүлэх банкаа өөрийн хүсэлтээр сонгосон ба хуучин тэтгэвэр авч байсан 582 иргэн банкаа сольж нийт 1871 тэтгэвэр авагч үйлчлүүлэх банкаа сонгосон.

Банкны тэтгэвэр барьцаалсан зээлийн нөхцөлтэй уялдуулан иргэдийн банк солих хөдөлгөөн тогтворгүй байна.




График 1. Банкуудаар үйлчлүүлж буй тэтгэвэр авагчийн тоо

Сар бүрийн 25-ны өдрөөр тэтгэврийн дансаа хааж 5 банкттай тооцоо нийлж олголтоо шалгаад дараа сарын файлаа банкуудад бэлтгэн өгч тэтгэврээ олгож байна. Сардаа 17.9 мянган хүнд сард 14.5 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгож, 7 хоног бүр группын сунгалт хийлгэж байгаа болон тэтгэврээ шинээр тогтоолгож байгаа иргэдэд олготыг жагсаалтаар тухай бүрд нь олгон үйлчилж байна.

2022 онд шинээр тогтоогдсон 1740 иргэний тэтгэврийн тогтоолт болон олголтыг тэтгэврийн 3 байцаагч тасгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр хуваарилан авч шалгасан. Шалгах хугацаанд илүү олгогдсон 3 тэтгэвэр авагчийн 3.1 сая, дутуу олгогдсон 8 тэтгэвэр авагчийн 5.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж шийдвэрлэн ажилласан. Мөн тэтгэвэр авагчидын өргөдөл хүсэлтийн дагуу жил нэмэх, цалин солих зэрэг үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай үзүүлэн үйлчилж байна. 563 хүсэлтийг биеэр хүлээн авч, 23 хүсэлтийг цахимаар хүлээн авч үйлчилсэн.

3.1.4 Тэтгэврийн даатгалын сангийн зардал

2023 оны аймгийн хэмжээд дундаж тэтгэврийн дүн 797.7 мянган төгрөг байна. Энэ үзүүлэлт нь 2022 оны дундажаас бага зэрэг буюу 19.5 хувиар өссөн байна. Баян-өндөр сум, Жаргалант сумуудаас 2023-2025 онуудад тэтгэврийн насанд хүрч байгаа иргэдийн нэгдсэн судалгааг авч нэгтгэхэд ирэх онуудад тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо тогтворжих хандлагатай байна.

Тэтгэврийн төрөл	2022 он		2023 он	
	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/
Өндөр нас	13317	103 990 864.2	13911	140 679 797 892.0
Тахир дутуу	2290	11 648 466.5	2142	12 829 041 408.0

Тэжээгчээ алдсан	654	3 775 567.0	663	4 523 482 032.0
Цэргийн	639	6 337 385.9	664	10 360 755 132.0
Нийт	16900	125 752 283.6	17380	168 393 076 464.0

Хүснэгт 1. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

3.2 ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН



2023 оны эхний хагас жилд аймгийн хэмжээд дундаж тэтгэврийн дүн 667.1 мянган төгрөг байна. Энэ үзүүлэлт нь 2022 оны дундажаас бага зэрэг буюу 1.01 хувиар өссөн байна. Баян-өндөр сум, Жаргалант сумуудаас 2023-2025 онуудад тэтгэврийн насанд хүрч байгаа иргэдийн нэгдсэн судалгааг авч нэгтгэхэд ирэх онуудад тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо тогтворжих хандлагатай байна.

3.2.1 Тэтгэмжийн даатгалын сангийн зардал

Тэтгэмжийн төрөл	2021 он		2022 он		2023 он	
	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/
ХЧТА-ны	12858	2 528 077.0	13594	2 657 825.3	11521	2 788 160.8
Жирэмсэн, амаржсан	2185	3 900 846.1	1877	3 794 242.7	1979	4 630 056.3
Оршуулгын	524	524 000.0	486	486 000.0	478	956 000.0
Нийт	15567	6 952 923.1	15957	6 938 068.0	13978	8 374 217.1

Хүснэгт 2. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

3.3 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН



2023 оны эхний байдлаар тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 430 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 4.3 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 33 иргэний тэтгэмжид 39.4 сая төгрөг, хиймэл эрхтэн, протез олгогдоогүй, нөхөн сэргээх зардалд 459 даатгуулагчид 345.6 сая төгрөгийн зардал тус тус зарцуулсан байна.

3.3.1 Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Зардлын төрөл	2021 он		2022 он		2023 он	
	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/
ТД-ийн тэтгэвэр	487	3 730 209.9	395	3 777 154.7	399	4 160 956.5
ТА-ийн тэтгэвэр	40	132 490.5	33	122 727.1	32	304 230.1
ХЧТА	43	28 369.6	42	42397.1	64	73 666.6
Сувилалын зардал	344	15 817.9	256	188 878.1	395	272 896.5
Хиймэл эрхтэн, протез	1	450.0	1	500.0		
Нийт	903	1 911 184.35	591	1 959 781.38	890	4 811 749,7

Хүснэгт 3.Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын үзүүлэлт

3.4 АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН



Ажилгүйдлийн даатгалын сангаас 856 даатгуулагч ажлаас чөлөөлөгдөж 2.9 тэрбум төгрөгийн тэтгэмж авсан байна. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад цар тахлын байдал буурсантай холбоотой харьцангуй тогтворжиж ААНБ-уудын үйл ажиллагаа хэвийн явагдаж цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор тэтгэмжийн зардал нэмэгдсэн байна.

3.4.1 Ажилгүйдлийн даатгалын сангийн зардал

Зардлын төрөл	2021 он		2022 он		2023 он	
	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/
Ажилгүйдлийн тэтгэмж	733	1 452 981.9	970	2 142 302.1	856	2 902 625.1

Сургалтын зардал	-	-	-	-	-	-
Нийт	733	1 452 981.9	970	2 142 302.1	856	2 902 625.1

Хүснэгт 4. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын үзүүлэлт

ДӨРӨВ. АРХИВЫН АЖЛЫН ТАЙЛАН

4.1 Архивын баримт хүлээн авах хуваарь гаргах, цахимжуулалт

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/07 тоот дугаартай “Баримт хүлээн авах хуваарь”-ийг хэлтсийн даргаар батлуулж тасаг, албадуудаас хуваарийн дагуу баримттай хамт ирүүлсэн жагсаалтын дагуу нэг бүрчлэн тоолж, архивт хүлээн авах баримтын бүртгэл хөтөлсөн. Хүлээн авсан баримтыг зохих стандартын дагуу цахим мэдээллийн санд бүртгэж мэдээллийн санг арвижуулсан. Тус хэлтсийн:

- ✓ Санхүү бүртгэлийн тасаг
- ✓ Үйлчилгээний тасаг
- ✓ Хамралт орлого шимтгэлийн тасаг
- ✓ Хяналт шалгалтын тасгуудаас нийт байнга болон түр 70 жил 70 жил хадгалах (зогсоогдсон хувийн хэрэг) 1216 хүлээж авсан.

Нийгмийн даатгалын төлөөлөгч Э.Сарангуа, Ч.Мягмарчулуун нартай хамтран архивт хадгалагдаж байгаа байнгын болон НДШ-ийн баримт тус бүр дээр, ТҮР болон 70 жил хадгалагдах баримтын хайрцаг тус бүр дээр нийт 8223 ширхэг баркод шошго нааж системд бүртгэсэн.

4.2 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлах

Байгууллага, салбарын үйл ажиллагаанд өдөр тутам үүсч хөтлөгдөж буй баримт бичгийг зөв ангилж бүлэглэх, хадгалах хугацааг оновчтой тодорхойлох, тэдгээрийг хэрг болгон бүрдүүлэх, тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл, лавлагаанд ашиглах зорилгоор 2023 оны 01-03 дугаар саруудад байцаагч ажмлтнуудаас санал авч 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдөр БНШКомисс хуралдаж “Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хөтлөх хэргийн жагсаалт”-ыг баталсан.

4.3 Баримт нягтлан шалгах комисс хуралдуулах

БНШК нь 2023 онд 2 болон түүнээс дээш хуралдах төлөвлөгөө гаргасны дагуу хамгийн эхний хуралаа 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хөтлөх хэргийн жагсаалт”-ыг баталж, хэлтсийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/07 тоот дугаартай “Баримт хүлээн авах хуваарь”-ийн дагуу хугацаандаа тасаг нэгжүүдээс баримтаа хүлээн авч дуусгасан талаар хэлэлцсэн.

4.4 Данс бүртгэл хөтлөх

2023 онд нэр төрлийн данс бүртгэл ашиглан нийт 1985 бүртгэл хийгджээ. Үүнд:

1. Ажилласан жил нөхөн тооцуулсан иргэдийн бүртгэл - 125
2. Архивын баримт түр ашиглуулсан бүртгэл - 101
3. Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн даргын тушаалаас хуулбарлан олгосон бүртгэл, Архивын хуулбар, хэсэгчилсэн хуулбар, баримтын сэдэвчилсэн жагсаалт олгосон бүртгэл - 19
4. Архивын лавлагаа олгосон бүртгэл /1995 – 2005/ - 592
5. 1991-1994 онуудад ажил олгогч байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан тухай лавлагаа олгосон бүртгэл - 127
6. Албан байгууллагад архивын лавлагаа олгосон бүртгэл - 324
7. Архивт хүлээн авсан баримтын бүртгэл - 45
8. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /QR кодтой/ - 41
9. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /Хүсэлт явуулсан бичгийн/ - 325
10. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /Хүсэлт ирүүлсэн бичгийн/ - 131
11. Эрхийн харьцаа дуусгавар болсон тэтгэврийн хувийн хэргээс материал авсан бүртгэл – 85
12. Архивын байрны дулаан, чийгшил болон цэвэрлэгээ хөтлөх бүртгэл – 32



Зураг 2. Архивын бүртгэлүүд

4.5 Нийгмийн даатгалын архивын лавлагаа олгох үйлчилгээ

2023 оны жилийн эцсийн байдлаар дараах 7 нэр төрлийн нийт **1665** лавлагааг гаргаж иргэн даатгулагч, ААНБ-уудад үйлчиллээ.

1. Ажилласан жил нөхөн тооцуулсан иргэдийн лавлагаа - 125
2. Архивын лавлагаа /1995 – 2005/ - 592
3. 1991-1994 онуудад ажил олгогч байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан тухай лавлагаа - 127
4. Албан байгууллагад архивын лавлагаа - 324
5. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /QR кодтой/-41
6. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /Хүсэлт явуулсан бичгийн/ - 325
7. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /Хүсэлт ирүүлсэн бичгийн/ - 131

4.6 Бусад аймаг, дүүрэгтэй цахимаар лавлагаа солилцох

Архив албан хэрэг хөтлөлтийн “Абле” системээр 2023 оны байдлаар

- ✓ Бусад аймаг дүүрэг рүү 325 лавлагаа захиалан авсан
- ✓ Бусад аймаг, дүүргээс 131 лавлагаа ирсэн


Нийтдээ 456 лавлагааг аймаг, дүүргийн хэлтсүүдтэй солилцсон байна.

4.7 Цахим лавлагаа, цахимжуулалт

2023 оны хагас жилд 41 QR кодтой лавлагааг хэлтэс дотооддоо тэтгэвэр, тэтгэмж тогтоох, төлбөр, зардал олгоход ашигласан байна. Энэ лавлагаа нь багассан нь E-Mongolia систем нэвтэрсэнтэй холбоотой бөгөөд архивын ажилтны ачааллыг эрс бууруулж байна.

Нийгмийн даатгалын нэгдсэн архивт хадгалагдаж байгаа байнгын болон НДШ-ийн баримт тус бүр дээр, ТҮР болон 70 жил хадгалагдах баримтын хайрцаг тус бүр дээр нийт 8859 ширхэг бар код шошго нааж системд бүртгэн цахимжуулсан.

№	Төрөл	Наагдах чип -н тоо	Хаана наагдах	Нийт
1	НДШ	7251	ХН тус бүр дээр	11713 мянган ширхэг хадгаламжийн нэгж тус бүрд чип нааж бүртгэсэн.
2	Байнга хадгалах	443	ХН тус бүр дээр	
3	Түр хадгалах	4019	Хавтас тус бүр дээр	





ТАВ.ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн танилцуулга

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт дотоод аудитын тасаг нь 6 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж аймгийн хэмжээнд 110 гаруй мянган иргэд, түүний дотор 18 мянга гаруй тэтгэвэр авагчид, давхардсан тоогоор 6 мянга гаруй даатгуулагчид тэтгэмж, нийгмийн даатгалд бүртгэлтэй идэвхтэй үйл ажиллагаа явуулж, тайлан өгч байгаа 1426 аж ахуй нэгж байгууллагын 28919 гаруй ажиллагсад, Нийгмийн даатгалын сайн дурын даатгалын 4303 даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Хяналт шалгалтын байцаагч нар нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн комисс, баримт нягтлан шалгах комисс, өмч хамгаалах комисс, ёс дэд хороо, төсөл хөтөлбөр инновацийн бүтээмжийн баг, авлигатай тэмцэх менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсэг болон хяналтын баг, гомдлын шаардлагын зөвлөл, соёл спорт залуучууд олон нийтийн идэвхижүүлэлтийн зөвлөл зэрэг хэлтсийн дэргэдэх 10 орон тооны бус комисс болон зөвлөлд ажиллаж байна.

5.2 Өдөр тутмын ажлууд

Аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн албан тоот, иргэнээс ирсэн өргөдөл, гомдол, саналын дагуу Хяналт шалгалт дотоод аудитын тасаг нь өдөр тутмын ажлуудад хуульд заасан заалт, тогтоол, шийдвэр, журамд үндэслэн шийдвэр гарган ажилласан байна. Мөн нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчиний, ажилгүйдлийн даатгалын сангуудаас олгогдож байгаа тэтгэвэр тэтгэмжид хяналт тавьж ажилласан.

5.2.1 Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 207 албан тоот, хүсэлтийг хүлээн авч хуулийн дагуу зөрчлийг барагдуулан ажилласан нь өмнөх оноос 25,8% буурсан байна.

- Улсын байцаагчийн акт – 57
- Улсын байцаагчийн дүгнэлтээр цалин залруулга – 60
- Улсын байцаагчийн дүгнэлтээр төрөл залруулга – 90

5.2.2 Иргэнээс ирсэн 65 өргөдлийг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж ажилласан нь өмнөх оноос 14% өссөн байна.

- Улсын байцаагчийн акт – 16
- Тэтгэвэр тогтоолтын үндэслэл дахин шалгах – 33
- Бусад – 16

5.2.3 2023 онд шинээр тэтгэвэр тогтоолгон авч байгаа 1180 тэтгэвэр тогтоолтыг тухай бүр хянан шалгаж ажилласан. Шинээр тогтоогдсон тэтгэврээс 253 зөрчил дутагдлыг илрүүлж тухай бүр нь засуулж, тэтгэвэр авагч нарт нэмж олгохоор 1,451,899.00 төгрөг, хасаж олгохоор 1,392,603.00 төгрөгийг шийдвэрлэж ажилласан.

5.2.4 Тэтгэмжийн 2 байцаагч, үйлчилгээний хэсгийн 9 байцаагчийн бодсон тэтгэмж олгох анхан шатны баримтыг хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн 4 байцаагч хяналт тавьж тэтгэмжийн даатгалын сангаас 2023 онд давхардсан тоогоор :

- Хөдөлмөрийн чадварын түр алдсаны тэтгэмжийг 11,1 мянган даатгуулагчдад 2,7 тэрбум төгрөгийн тэтгэмжийн бодолтонд 76 илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулж, нэмж олгохоор 2,403,398.58 төгрөг, хасаж олгохоор 1,733,183.00 төгрөгийг шийдвэрлэж ажилласан байна.
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 1,8 мянган даатгуулагчдад 4,3 тэрбум төгрөгийн тэтгэмжийн бодолтонд 32 илэрсэн зөрчил дутагдлыг

тухай бүр нь засуулж, нэмж олгохоор 1,259,790,34 төгрөг, хасаж олгохоор 2,015,404.27 төгрөгийг шийдвэрлэж ажилласан байна.

5.2.5 Үйлдвэрийн ослын даатгалын даатгалын сангаас 2023 онд хөдөлмөрийн чадварын түр алдсаны тэтгэмжийг 57 даатгуулагчдад 65,3 сая төгрөг, сувиллын газрын тусламж үйлчилгээний болон ирэх, очих унааны зардлыг нийт 51 даатгуулагчид 9,9 сая төгрөгийн зардлыг хянаж 2 илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулж, хасаж олгохоор 13,000.00 төгрөгийг шийдвэрлэж ажилласан байна.

5.2.6 Ажилгүйдлийн даатгалын сангаас 2023 онд шинээр тогтоогдон олгогдож байгаа ажилгүйдлийн 796 хүний 2,8 тэрбум төгрөгийн тэтгэмжид хяналт шалгалт хийж 52 зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулж, нэмж олгохоор 1,327,784.00 төгрөг, хасаж олгохоор 3,392,581.00 төгрөгийг шийдвэрлэж ажилласан.

5.3 Нийгмийн даатгалын тухай хууль болон Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт

Улсын байцаагчийн актын 2023 оны эхний үлдэгдэл 14,3 сая төгрөг байсан. 2023 онд Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, аж ахуйн нэгж, байгууллагын албан хүсэлт, иргэдийн өргөдлийн дагуу нийт 215 байгууллагын санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж, цалин залруулгын дүгнэлт 60 байгууллага, төрөл залруулгын дүгнэлт 90 байгууллагад бичиж, ААНБ-ын санхүүгийн баримт, НД-ын сангийн зарцуулалтад хяналт шалгалт, дотоод аудит хийж 121 зөрчилд улсын байцаагчийн акт болон зөрчлийн тухай хуулийн хялбаршуулсан журмаар нийт 48,9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, алдангийг төвлөрүүлэн ажилласан. Үүнээс зөрчлийн тухай хуулиар 45 аж ахуйн нэгж, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж хуульд заасан хугацаанд төлөгдөөгүй орхигдуулсан 11,1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, алдангийг бүрэн нөхөн төлүүлж, зөрчилд 14,0 сая төгрөгийн торгуулийг тавьж 100 хувь бүрэн барагдуулан ажилласан.

5.4 Төлөвлөгөөт хяналт, шалгалт

2023 онд Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь хэлтсийн даргаар удирдамж батлуулж дараах 8 чиглэлийн хүрээнд холбогдох хууль, тогтоомж, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж зөвлөмж өгч, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

5.4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр баталсан 06/668 тоот чиглэлийн 1 зүйлийн 1.2 дахь заалтыг үндэслэж нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны 02 сдугаар сарын 01-ний өдрийн 01 дугаартай удирдамжийг хүчингүй болгож 120 ба түүнээс дээш насжилттай нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр авлагатай 357 байгууллагуудад Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан А/186 тоот хяналт шалгалтын нэгдсэн зааврын дагуу хяналт шалгалт хийж, авлага барагдуулах талаар шат дараалсан арга хэмжээг авч, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, зөвлөн туслах болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллаж байна.

5.4.2 Нийгмийн даатгалын хэлтсийн даргын баталсан №3 дугаар удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйл, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 1/1066 тоот албан зөвлөмж зэргийг баримтлан 2018-2021 оны Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтсээс олгосон оршуулгын тэтгэмжийг шалгаж ажилласан. 2018-2021 онд нийт 1877 иргэнд оршуулгын тэтгэмж олгож ажилласнаас, ажилласан жилийн материал дутуу, мэдээллийг буруу оруулсан, цэргийн тэтгэвэр авагчид олгосон зэрэг зөрчил дутагдалтай 20 иргэнд олгосон зөрчил илэрсэн байна.

ХШДАТ-аас 2023 онд дотоод аудит хийж, дараах зөвлөмжийн дагуу:

1. Үйлчилгээний хэсгийн ахлах долоо хоног бүрийн Лхагва гаригт өглөө бүр хууль, дүрэм, журмын дагуу бүрдүүлэх материалын талаар сургалт орж хэвшсэн байна.
2. Оршуулгын тэтгэмж олгох хуудсыг Үйлчилгээний тасгийн дарга мэдээллийн сантай ажилласан жилийг тулган шалгаж баталгаажуулдаг болсон.
3. Зөрчилтэй оршуулгын тэтгэмжийг олгосон байцаагч тус бүрт хувийн хэргийг нягтлан шалгаж, ар гэртэй нь холбогдон орхигдсон ажилласан жил болон хугацаат цэргийн алба хаасан эсэхийг тодруулан лавлагааны захиалга өгөх ажиллагаа явагдаж байна.

5.4.3 Нийгмийн даатгалын байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийг эрсдлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, төрийн байгууллагад авлига бий болох шалтгаан нөхцөлийг арилгах,

хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг чангатгах, шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор олон улсын ISO 37001:2016 стандартад нийцсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг манай байгууллага 2022 оноос эхлэн үе шаттайгаар, холбогдох стандартаар тогтоосон шаардлагын дагуу нэвтрүүлж ажилласан.

Монгол Улсын Төрийн байгууллага дундаа анх удаа хэрэгжүүлж 2023 онд Авлигын эсрэг ISO 37001:2016 стандартад нэвтрүүлж БНЭУ-ын олон улсын баталгаажуулалтын QFC байгууллагын батламж гэгчилгээг БНЭУ-ын Элчин сайдаас гардан авсан. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Мөн байцаагч ажилтнуудтай гүйцэтгэлийн төлөвгөөнд авлигын талаар заалт оруулан батлуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

5.4.4 Орхон аймгийн Жаргалант сумын байцаагчийн ажлын гүйцэтгэлд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, тэтгэврийн хувийн хэргийн бүрэн байдал, орлогын төлөвлөгөөний биелэлт, өр авлагын барагдуулалт, малчны зөвлөлийн тогтоолын үндэслэл, мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байдал зэрэгт хяналт шалгалт хийж ажилласан.

Хяналт шалгалтын дүнгийн талаар :

5.4.4.1 Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг журмын дагуу авч байгаа эсэх, орлогын төлөвлөгөө биелүүлэх, өр авлага барагдуулах талаар зохион байгуулсан ажил үйлчилгээ:


Нийгмийн даатгалын сангийн орлогын сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлт, түүний гүйцэтгэлд бүртгэлээр хяналт тавин 2023 оны эхний 5 сарын байдлаар 367 404,25 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулахаас 358 567,44 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж 97,6 хувийн биелүүлсэн байна.

2023 он	Орлогын төлөвлөгөөний биелэлт		
	Төлөвлөгөө /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/	Хувиар

1 дүгээр сард	73 480,85	25 920,85	35.3%
2 дугаар сард	73 480,85	100 981,93	137.4%
3 дугаар сард	73 480,85	73 474,09	99.9%
4 дүгээр сард	73 480,85	95 467,31	129.9%
5 дугаар сард	73 480,85	62 723,44	85.4%
Дүн	367 404,25	358 567,44	97.6%

Нийт 23 аж ахуй нэгж байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан өгч байгаагаас 18 аж ахуй нэгж байгууллага тоон гарын үсэг ашиглан цахимаар тайлан өгч байна. 2023 оны эхний 5 сарын байдлаар шинээр 1 аж ахуйн нэгж бүртгүүлэн, нийгмийн даатгалд хамрагдсан, 1 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаагаа зогссон байна.

2023 оны эхний үлдэгдэл өр авлага 7 байгууллагын 26,9 сая төгрөг байсан нь 11 байгууллагын болж 72,9 сая төгрөг болж 171 хувиар нэмэгдсэн байна.



Өр авлага бууруулах зорилгоор Сэлэнгэ – Ачуут ББН, Худагтрейд ХХК, Жаргалант сургууль, Жаргалант ЭМТөв гэсэн байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага өгч ажилласан байна.

5.4.4.2 Тэтгэвэр авагчдын хувийн хэрэгт тооллого хийхэд:

Жаргалант сумын тэтгэврийн архивд хадгалагдаж байгаа нийт 697 ширхэг хувийн хэргийг тэтгэврийн программаас тэтгэвэр авагчийн массив хэвлэн авч нэг бүрчлэн

тулган тоолоход бүрэн байна. Нас барсан 7 иргэний тэтгэврийн хувийн хэргийг тухай бүр нь татан хэлтсийн архивд хүлээлгэн өгч ажилласан байна.

5.4.4.3 Мэдээллийн ил тод байдал, даатгуулагч, ажил олгогчдын мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажилласан байдал:

Засгийн газрын 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж төрийн мэдээллийг нээлттэй ил тод болгох цахимжилтыг эрчимжүүлэх, хүнд суртлыг арилгах зорилгоор “Шил ажиллагаа”-г эхлүүлж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг ил тод мэдээллийн самбарт байршуулсан боловч зарим мэдээллийн тоон үзүүлэлтийг хуулийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлээгүй байна.

5.4.4.4 Малчны зөвлөлийн тогтоолын үндэслэл:

“Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл”-ийн 2018 оноос 2022 оны хооронд хугацааны Орхон аймгийн Жаргалант сумын даатгуулагчийн малчнаар даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлд 5 хүн орсноос 4 хүн дээр мал малласан тухай тогтоол гарсан байна. Малчны зөвлөлийн тогтоол, тэмдэглэл, бүрдүүлсэн баримт бичгийг үндэслэлийг хууль, тогтоол, шийдвэр, дүрэм, заавар журмыг баримтлан шалгахад Чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO 9001:2015 (Монгол улсын MNS ISO 9001:2016) стандартыг нэвтрүүлснээр гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг олон улсын ISO9001 стандартад нийцүүлж, чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангаж, өрөөний эмх цэгц, ажлын бүртгэл зэрэгт байнгын сайжруулалт хийн ажиллаж байна. Авлигатай тэмцэх менежментийн тогтолцооны олон улсын ISO 37001:2016 стандартын АЭМТХАХ-ийн авлига, хээл хахуулийн эсрэг зохион байгуулсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээг тухай бүр нь хэрэгжүүлэн, түүнд дэмжлэг үзүүлэх, ёс зүйн соёлыг сайжруулахад анхаарч ажилласан байна.

ХШДАТ-аас 2023 онд дотоод аудит хийж, дараах зөвлөмжийг өгсөн:

1. НДЕГ-ын 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах тухай” А/16 тоот тушаалын дагуу 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 06/410 тоот “Нийгмийн

даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх ажлын нэгдсэн удирдамж"-ыг хэрэгжүүлэн, өр авлага бууруулах ажлыг эрчимжүүлэн ажиллах

2. Мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчлэн, агуулгыг хянаж, өөрчлөлт гарсан тухай бүр шинэчлэн ажиллах
3. 2023 онд иргэдээс цахим болон цаасан сууриар сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тооцон ажиллах
4. Малчны зөвлөлийн цаасан суурьт баримтыг архивын баримт болгон хадгалахад дотоод товъёгийн хэсэгт хурлаар хэлэлцсэн иргэдийн мэдээллийг оруулах, зөвлөлийн хурлын тэмдэглэлд бүх гишүүдийн гарын үсэг зурж баталгаажуулаагүй, 2008 -2013 оны баримтаар 1995-2000 онд мал малласан байсныг нотлох баримтаар хавсаргасан, Багийн засаг дарга малчны мал маллаж байсныг тодорхойлохдоо ямар нэгэн албан баримт бичигт үндэслээгүй зэрэг зөрчлийг дахин давтахгүй байхад анхаарч ажиллан Монгол улсын засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 тоот тогтоолын заалтыг нэг бүрчлэн хэрэгжүүлэн ажиллах, Багийн засаг даргын тодорхойлолтыг ямар нэгэн албан бичигт үндэслэн гаргуулж албажуулах байдлаар хэвших.

5.5.1 Хяналт, шалгалт дотоод аудитын тасгийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хэлтсийн даргаар батлуулсан 2023 оны төлөвлөгөөнд заасны дагуу удирдамж №5 боловсруулан 2020-2022 оны хооронд хугацааны Баян-Өндөр сумын 22 иргэний, 2018-2022 оны Жаргалант сумын 3 иргэний нийт 25 тогтоолын үндэслэлийг шалгаж гарын үсэг, хавсралт баримт дутуу байсан 5 зөрчлийг арилгуулах, нотлох баримтын шаардлага хангахгүй байгаа 8 иргэний баримтын зөрчлийг арилгах зөвлөмж тайланг хугацаандаа гарган хүргүүлж 90,9% үр дүнтэй, хэрэгжилтийг 100% ханган ажилласан.

5.5.2 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт мөн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орсон заалтаар тэтгэврийн хувийн хэргийг хагас жил, бүтэн жилээр тоолох төлөвлөгөөт ажлын дагуу хувийн хэргийн эмх цэгц, бүрэн бүтэн байдал зэргийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх цаашид хуулийн хэрэгжилтийг хангахад туслан зөвлөх зорилгоор шалгахад тэтгэврийн архивын 16683 хувийн хэргийг хагас жилээр, 18676 хувийн хэргийг бүтэн жилээр нэг бүрчлэн массивтай тулган тоолж,

хуучирч муудсан хавтас хайрцаг шинэчилж сольж, давхар цахим тоологчоор тоолоход хувийн хэрэг 100 хувь бүрэн тоологдсон. Шалгалтаар 1 иргэний нас барсаны дараа илүү олгосон 6-н сарын 2,7 сая төгрөгийг тэтгэврийг нөхөн төлүүлэх зөвлөмжийг үйлчилгээний тасагт өгснөөс үр дүн 0%, хэрэгжилт 100% байна.

5.5.3 Хяналт, шалгалт дотоод аудитын тасгаас архивын улсын үзлэгтэй холбогдуулан Нийгмийн даатгалын хэлтсийн 2022-2023 оны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмын дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг шалгаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, 4 заалтаар зөвлөмж өгч ажилласан.

5.5.4 Орхон аймгийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн төлөвлөгөөний дагуу Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох эрхзүйн заалтын дагуу үйл ажиллагааны зардлын зарцуулалт, үндэслэх баримт мэдээллийг шалгаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, 5,5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулах, анхан шатны баримтын гарын үсэг, баримтны иж бүрдлийг хангуулах, албан тушаалбн нэршлийг залруулах 4 заалтаар зөвлөмж өгч ажилласан.

5.6. Дээд газраас өгсөн чиглэлийн дагуу хийгдсэн хяналт шалгалт

5.6.1 Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар Нийгмийн халамжийн сан болон Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн давхардлыг шалгаж 2,2 сая төгрөгийн зөрчил дээр 1 албан шаардлага өгч 100% барагдуулсан, 1,09 сая төгрөгийн зөрчил дээр акт өгч 91% барагдуулсан.

5.6.2 Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдамж 06/787 тоотын дагуу Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч төлөвлөгөөний дагуу 14 байгууллагыг шалгаж 5 заалтаар 3 албан шаардлага өгч 85% үр дүнтэй, хэрэгжилт 100% хангуулсан.

5.6.3 Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр баталсан 06/668 тоот чиглэлийн 1 зүйлийн 1.2 дахь заалтыг үндэслэж 3 саяас дээш өр авлагатай нийт 26 ААНБ-ын 11 181.2 сая төгрөгний цалингийн сантай 1304 даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогод шалгалт хийж өр авлага барагдуулахад шат дараалсан арга

- хэмжээ авч 2 038.5 сая төгрөгийг барагдуулан ажилласан байна. 100.0 сая төгрөгнөөс дээш өртэй 11 байгууллагын 3 529.1 сая төгрөгний хуримтлагдсан шимтгэлийн авлагатай ААНБайгууллагуудаас 3 улирлын байдлаар 3 байгууллагын 1 728.8 сая төгрөгийг барагдуулаад байна.
- 5.6.4 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/2267 тоот үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд хүргүүлсэн.
- 5.6.5 Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрээр ажилд нь эргүүлж томилсон ажилтнуудад олгосон нөхөн олговор, түүнийг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлсэн талаарх судалгаа гаргаж явуулсан. /хамарсан хугацаа: 2016-2023 он/
- 5.6.6 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын сарын 24-ний өдрийн а/16 дугаар тушаалаар өгсөн үүргийн биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэн 120 ба түүнээс дээш насжилттай Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр авлага барагдуулах ажлын төлөвлөгөөний дагуу 26 аж ахуй нэгж байгууллагын 1,8 тэрбум төгрөгний гэрээ байгуулж, үүнээс 2 038.5 сая төгрөгний өр авлагыг барагдуулан ажиллаж байна. Үйл ажиллагаа нь зогссон 2 ажил олгогчийн үйл ажиллагаа нь сэргэсэн. Ажил олгогчийг шалгаж зөрчлийн тухай хуулиар торгож, 4.8 сая төгрөгний акт, 2.4 сая төгрөгний алданги төлүүлэн бүрэн барагдуулсан.
- 5.6.7 Нийгмийн даатгалын ерөнхий газрын 02/1275 тоотын дагуу 440 тэтгэвэр авагчийн мэдээллийг тулган шалгаж тайланг хүргүүлэн 100% хангасан.

5.7. Зорилтот жилийн хүрээнд

“НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЖИЛ”-ийн хүрээнд төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу:

- 5.7.1 65 байгууллагад шалгалт хийж 48,9 сая төгрөгийн зөрчил дээр акт тавьж 43,4 сая буюу 92,7% барагдуулсан, 26 ААНБ-ын 11 181.2 сая төгрөгний цалингийн сантай 1304 даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогод шалгалт хийж

өр авлага барагдуулахад шат дараалсан арга хэмжээ авч 2 038.5 сая төгрөгийг барагдуулан ажилласан байна.

5.7.2 Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч төлөвлөгөөний дагуу 14 байгууллагыг шалгаж 5 заалтаар 3 албан шаардлага өгч 85% үр дүнтэй, хэрэгжилт 100% хангуулсан.

5.7.3 Сургалт сурталчилгааны комиссын төлөвлөгөөний дагуу 28 төсвийн байгууллагын 28 нягтлан, 15 дээш ажилтантай төсвийн болон хувийн хэвшлийн 43 байгууллагын 1042 даатгуулагчид, Өрхийн эрүүл мэндийн төвийн 8 байгууллага, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Медикал эмнэлэг, Эрдэнэт сувилал нийт 82 байгууллагын 1261 даатгуулагч нарт Нийгмийн даатгалын шинэчлэгдсэн багц хууль, Эмнэлгийн хуудас олгох журмаар танхимын сургалт орж мэдлэг олгож ажилласан. Цахимаар “Сайхан бүхний эхлэл шинэ өглөө байдаг, өглөө бүрийг шинэ мэдээлэлтэй, эрч хүчтэй эхлүүлцгээе” бичлэг бэлтгэж, 4 удаагийн шууд лайвт орж нийт 13,2 мянган хүнд мэдээлэл хүргэж ажилласан.

5.8. Цахим хяналт

Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”- (<http://10.9.0.5/monitoring>) -д нийт 4248 алдаатай байх магадлалтай мэдээллийн 89% шалгаж, үндсэн баримт болон нотлох баримтыг үндэслэн зөрчил мөн эсэхийг тогтоож, тухайн тогтоогдсон 5 зөрлийг арилгах арга хэмжээ авч 1,1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулан, цалингийн 60, төрлийн 90 залруулга хийгдэж ажиллаж байна.

5.9. Бусад ажил болон сургалт сурталчилгааны талаар

Тайлант хугацаанд өдөр тутмын ажлаараа 207 аж ахуй нэгж байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хуулийн шинэчлэлийн талаар мэдээлэл хүргэн ажилласан. Мөн хэлтсийн нийт байцаагч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж, шаардлагатай тохиолдолд дээд шатны байгууллага, холбогдох байгууллагуудын албан хаагч, мэргэжилтнүүдтэй холбогдож ойлголтын зөрүүг арилгаж, шаардлагатай тохиолдолд сургалт, зөвлөгөө, мэдээлэл авч ажиллаа.

Хэлтсийн дэргэдэх орон тооны бус комиссоос зохион байгуулагдсан ажил, иргэд даатгуулагч нарт чиглэсэн “Нээлттэй хаалга”, “Сургалт сурталчилгаа”, “Цахим лайв”

зэрэг олон нийтийн ажлуудад төлөвлөгөөний дагуу тасгийн 4 байцаагч идэвх санаачлагатай 100 хувь бүрэн оролцож ажилласан.

Гомдлын шаардлагын зөвлөлд 31 иргэний өргөдөл, 2 албан тоотыг 10 удаагийн хурлаар тоотыг шийдвэрлэн ажилласан.

Хяналт шалгат, дотоод аудитын тасгийн байцаагч нар дараах сургалтуудад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлж ажилласан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан “Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх” цахим сургалтанд 3 байцаагч, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газраас “Бодлого- Хэрэгжилт-Хяналт ” сэдэвт танхимын 3 өдрийн нэгдсэн сургалтанд 1 байцаагч, Орхон аймгийн Прокурорын газраас “Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт 3 удаагийн танхимын сургалтанд 5 байцаагч бүрэн хамрагдсан.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс хяналт шалгалтаас бусад чиглэлээр зохион байгуулсан дотоодын танхимын 25 удаагийн сургалтанд Хяналт шалгалтын 5 байцаагч давхардсан тоогоор 89 удаа хамрагдаж хуулийн мэдлэг, монгол бичиг, ёс зүй, харилцааны чадвараа дээшлүүлэн ажилласан.

ЗУРГАА. САНГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ

6.1 Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж хамрагдах хүний тоо, орлогын төлөвлөгөөг төсвийг хуваарийг дагуу биелүүллээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогын сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж 2023 оны жилийн эцсийн байдлаар 170.796,3 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулахаас 175.066,2 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж 102.5 хувийн биелүүлсэн.

2023 онд 1425 ажил олгогч байгууллагын 28886 даатгуулагчийн 175.066,2 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг санд төвлөрүүлж шинээр 105 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан байна.

6.2 Нийгмийн даатгалын хамрагдалт

Нийгмийн даатгал төлдөггүй тодорхой ажил хөдөлмөр эрхлэдэггүй иргэн, малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын ач холбогдол, хууль тогтоомжийг сурталчилан таниулах тэднийг сайн дурын даатгалд хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна.

Нийгмийн даатгалд хамрагдаагүй ААНБ 2023 онд шинээр 105 ААНБ бүртгэж 507 албан журмын даатгуулагчийг хамруулсан байна.

Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/114 дүгээр захирамжийн дагуу “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхчүүд”-ийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Засаг даргын Төсөл хөтөлбөрийн зардлаас хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 104 эцэг эхчүүдийг сайн дурын даатгалд хамруулж 114.3 сая төгрөгийн шимтгэл, 99 хүнийг эрүүл мэндийн даатгалд хамруулж 6.7 сая төгрөгийн шимтгэл нийт 120.9 сая төгрөгийн шимтгэлийг шимлжүүлэн хамрагдалтыг нэмэгдүүлэн ажилласан. Иргэдийн мэдээллийг тухай бүрт нийгмийн даатгалын нэгдсэн системд оруулан даатгуулагчид мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажилласан.

Нийгмийн даатгалд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй идэвхтэй тайлан ирүүлсэн 1425 аж ахуйн нэгж байгууллагад хяналт тавьж хөдөлмөрийн хөлснөөс доод хэмжээгээр тайлагнаж буй эсэхэд хяналт тавьж ХХДХ нээс доош цалин хөлснөөс тайлагнаагүй байна.

Нийгмийг соён гэгээрүүлэх замаар нийгмийг эрсдлээс хамгаалах зорилтын хүрээнд цахим орчноор мэдээлэл дамжуулан ажиллаж байгаа нь цаг хугацаа орон зайнаас үл хамааран өдөр тутамд нийгмийн даатгалын мэдээ мэдээллийг хуулийн хүрээнд сурталчилан ажиллаж байна.

Энэхүү утсаар мэдээлэл түгээх ажил маань иргэдийн явдал чирэгдлийг багасгах мөн нийгмийн даатгалын байцаагчийн ажлын ачааллыг бууруулах, хамралтыг нэмэглүүлэх чиглэсэн ажил юм.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021.11.28-ний өдрийн А/182 тушаалын дагуу “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авах, баталгаажуулах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж 1425 аж ахуйн нэгжийн тайланг цахим болон web-ээр хүлээн авч хэвшүүлэн ажиллалаа.

“Мал аж ахуйн хаваржилт цаг үеийн ажлаар” –ын удирдамжийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд Даваа, Ямаатын даваа, Хонгорын овоо, Хангал өртөө зэрэг 11 чиглэлд Баян-Өндөр сумын ХААТ-ын мэргэжилтэн, хүний их эмч, малын эмч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нийт 394 иргэнд Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, малчны тэтгэврийн тухай, 0-3 настай хүүхэдтэй эхийн сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалын тухай мэдээллийг хүргэн тэдний шимтгэл төлж ажилласан жилийн тооцож шинээр **32** малчин иргэнийг нийгмийн даатгалд хамруулан ажиллалаа.

Орхон аймгийн Засаг даргын дугаар захирамжийн дагуу 5,6 саруудад Нээлттэй хаалганы өдөрлөгийг худалдааны томоохон төвүүдэд зохион байгуулахаар ажлын төлөвлөгөө гарган хуваарийн дагуу Баян, Төгөл, Хангайн бүс худалдааны төв, Хүлэг зах, Үйлчилгээний төв, Есөн Эрдэнэ худалдааны төв, Зуун айл худалдааны төвүүдэд зохион байгуулж хамрагдалтыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Шинээр сайн дурын даатгалд **637** хүнийг даатгасан байна.

НДЕГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 04/142 тоот албан тоот бичгийн дагуу шинээр хамруулах ажил олгогч албан журмаар даатгуулагч, нийгмийн даатгал төлдөггүй тодорхой ажил хөдөлмөр эрхлэдэггүй иргэн, малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах, зорилгоор 10 дугаар сард удирдамж гарган нийт 26 багт 42 байцаагч ажилтныг хуваарилан баг тус бүрт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын судалгаа, ажилгүй болон хүүхдээ асарч байгаа эхийн судалгааг авч шинээр **274** даатгуулагч сайн дурын даатгалд хамруулан ажилласан байна.

“Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэсэн найруулга” ач холбогдол, хууль тогтоомжийг сурталчилан таниулах зорилгоор **136** ажил олгогч **4621** даатгуулагчид сургалт зохион байгуулан ажилласан байна.

Ньюкомпас ХХК-тай хамтран тоон гарын үсгийн эрх үнэ төлбөргүй олгон ажиллаж тоон гарын үсгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр хүлээн авах ажлыг эрчимжүүлэн өмнөх онд **753** ААНБ-ын тайлан авч байсан бол энэ онд **1066** ААНБ тайлан ирүүлсэн буюу **41.5** хувийн өсөлттэй байна.

- Web-ээр 359 ажил олгогчийн 4308 тайлан ирүүлж,
- Тоон гарын үсгээр 1066 ажил олгогч 11939 тайланг хүлээн авч баталгаажуулан ажиллалаа.

Энэ онд

- Регистер нэгтгэсэн – 32 даатгуулагч
- Регистр зассан – 24 даатгуулагч
- Цалин өөрчилсөн – 198 даатгуулагч
- Цалингийн залруулга – 61 ААНБ
- Төрлийн залруулга – 90 ААНБ

НДЕГ-аас ирүүлсэн 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/1883 тоот бичгийн дагуу нийгмийн даатгалын мэдээллийн ситемийг цогцоор нь шинэчилж 2024 оны 01дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэхтэй уялдуулан **344** гадаад иргэний мэдээллийг гадаадын иргэн, харъяатын газраас олгосон 13 оронтой тоогоор шинэчлэн судалгааг хийж бүртгэн ажилласан байна.

НДЕГ-аар газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/2105 тоот албан бичгийн дагуу **576** аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг УБ-ын баазад тулган шалгаж нийгмийн даатгалын мэдээллийн санд засаж залруулан ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/16 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг:

- ✓ Сарын мэдээ- 12 удаа,
- ✓ Сар бүрийн 15-ний мэдээ-12 удаа,
- ✓ Мягмар гарагийн мэдээ-51 удаа тус хүргүүлсэн байна

6.3 Өр авлага барагдуулалт

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагыг барагдуулах ажлын хүрээнд дараах шат дараалласан арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

Уулзалтаар – 695 ААНБ-ын 3112.3 сая төгрөгийн өр авлагыг талаар уулзалт хийсэн бол 333 ААНБ-ын 2259.6 сая төгрөгийг барагдуулан ажилласан. БИЕЛЭЛТ – 72.6%

Хуваарь гаргаж – 40 ААНБ-тай 2027.7 сая төгрөгийн авлага бууруулах хуваарь байгуулсан бол үүнээс 33 ААНБ-ын 1960.7 сая төгрөгийн авлагыг бууруулан ажилласан. Хуваарийн дагуу төлөлт хийгээгүй хүлээсэн хариуцлагаа хуулийн хугацаанд биелүүлээгүй ААНБ-ыг дараагийн шатны арга хэмжээрүү шилжүүлэн ажиллаж байна. . БИЕЛЭЛТ – 96.6%

Данс хаасан – 112 ААНБ-ын 1,895.3 сая төгрөгийн авлагатай холбоотойгоор ААНБ-ын харилцах данс хааснаар 22 ААНБ-ын 459.2 сая төгрөгийн авлагыг бууруулан ажилласан байна. БИЕЛЭЛТ – 24.2%

Албан шаардлага - 49 ААНБ-ын 1765.6 сая төгрөгийн авлагад шаардлага хүргүүлснээр 41 ААНБ-ын 371.1 сая төгрөгийн авлага барагдуулсан байна. БИЕЛЭЛТ – 21%

Шүүхэд шилжүүлсэн – Өмнөх онуудад шүүхэд шилжсэн 26 ААНБ-ын 1.803,2 сая төгрөгийн авлага байгаагаас 379,5 сая төгрөгийн авлага барагдуулан ажилласан байна. БИЕЛЭЛТ – 21%

Өмнөх оны хуримтлагдсан өр авлагыг 2.163,4 сая төгрөгөөр барагдуулан нийт авлагын 51.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан боловч тус онд шинээр 3.225,6 сая төгрөгийн авлага үүссэн байна. Авлага барагдуулах ажлыг шат дараатайгаар авч тус оны эцэст 60 хувийн биелэлттэй ажиллахаар зорьж байна. Авлага барагдуулах ажлыг шат дараатайгаар авч тус оны эцэст 60 хувийн биелэлттэй ажиллахаар зорьж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 01/2123 дугаар чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж төрийг төлөөлөх эрхийн хүрээнд Прокурорын байгууллагатай хамтран ажиллаж өр авлага барагдуулан ажиллаж байна.

НДЕГГазар болон УБЕГ-тай мэдээллийг цахим хэлбэрээр солилцох хамтын ажиллагааны хүрээнд <http://opendata.burtgel.gov.mn/> сайтын ашиглан мэдээлэл солилцон ажиллалаа.

Төрлийн залруулга 76 байгууллагад хийж өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

ДОЛОО. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн тайланг улирал бүр нийт 4 удаа гаргаж НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газарт хянуулж баталгаажуулсан. Мөн төсвийн гүйцэтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэгдсэн санхүүгийн тайлангуудыг хагас жилээр 2 удаа хуулийн хугацаанд гаргаж хүргүүлэн баталгаажсан тайланг сангийн яамны прораммд оруулан ажиллалаа.

Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 5/841 тоот Нийгмийн даатгалын сарын мэдээ гаргахад баримтлах чиглэл албан бичгийн дагуу дараах мэдээг бэлтгэн ажилласан:

- 6 банкны 35 дансны орлого, зарлагыг харилцах программд бүртгэж үлдэгдлийг өдөр бүрээр тааруулж, банктай улиал бүр тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулсан;
- Сангийн мэдээний сан тус бүрийн мөнгөн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэлийг харилцахын үлдэгдэл мэдээтэй тулган шалгах;
- Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний төлөвлөгөөг шивж оруулан Сангийн мэдээний бусад орлого зарлагыг мөнгөн гүйлгээний цэвэрлэгээний тайлангийн дүнгээр цэвэрлэн нийт 5 төрлийн мэдээг 6 удаа гаргаж хэмнэлт хэтрэлтийн тайлбарын хамт дараа сарын 02-ны өдөрт багтаан бэлтгэж баталгаажуулан хянуулж ажилласан. Мөн хэлтсийн вэб сайтад мэдээг сар бүр байршуулсан;
- Байгууллагын урсгал болон үйл ажиллагааны зардлын мэдээг 6 удаа гарган өгсөн;
- Сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ, тоон мэдээг сар бүрийн эхэнд ЗДТГ-ын Статистикийн хэлтэст хүргүүлэн ажилласан;
- Шилэн дансны тухай хуулийг баримтлан үйл ажиллагааны 68 , сангийн 62 мэдээг хуулийн хугацаанд хийж ил тод болгосон.

7.1 Үйл ажиллагааны зардлын зарцуулалтын талаар

Байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан “Үйл ажиллагааны зардлын 2023 оны төсвийн сарын хуваар”-ийн дагуу зардлын ангилал тус бүрээр зарцуулан ажилласан байна. Байгууллагын урсгал зардал жилээр 1154.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгөө батлагдаж жилийн эцсийн байдлаар 1008.4 сая төгрөгийг зарцуулан ажилласан. Аймгийн ЗДТГазраас санхүүжүүлдэг Нийгмийн даатгалын төлөөлөгч хөтөлбөрт 78.9 сая төгрөгийн санхүүжилт авсан ба 10 төлөөлөгчийн цалин хөлсөнд зарцуулан ажиллалаа.

7.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн талаар

Сангийн 2 нягтлан бодогч банкуудын харилцах дансны гүйлгээг дараа өдөр нь сан тус бүрээр тулган сангийн нэгдсэн программд мэдээллийг үнэн зөв бүртгэж ажилласан. Мөн гүйлгээний утга тодорхойгүй 1200 орчим даатгуулагчийн гүйлгээг тухай бүр залруулан ажилласан байна.

Сангийн орлого зарлагын гүйлгээний бичилт тоо /6 банкны 5 сан/

№	Сан/Банк	Хаан	Капитро н	Голом т	ХХБ	Төрий н сан	Төрий н банк	Нийт гүйлгэ э
1	Төвлөрсөн	40975	605	1958	2330	2526	3771	52165
2	Тэтгэврийн	3097	363	2100	437	10	2364	8371
3	Тэтгэмжийн	1957	268	1826	677	0	2409	7137
4	ҮОМШӨ	255	114	75	123	0	313	880
5	Ажилгүйдлий н	3795	11	0	0	0	27	3883
6	ЭМД	4120	18	89	40	8871	864	14002
Нийт гүйлгээний тоо		54199	1379	6048	3607	11407	9748	86438

7.3 Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

2023 онд 1221 ажил олгогч байгууллагын 152.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг санд төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого сүүлийн 5 жилийн байдлаар 104%-122% хүрч орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

2023 оны шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	118 924.7	120 856.6	1 931.9	101.6%
2	Тэтгэмжийн даатгалын сан	12 292.3	12 649.5	357.2	102.9%
3	ҮОМШӨ даатгалын сан	14 513.8	16 307.2	1 793.4	112.4%
4	Ажилгүйдлийн даатгалын сан	2 369.7	2 590.8	221.1	109.3%
Дүн		148 100.5	152 404.1	4 303.6	102.5%

Дүгнэлт: Тайлант үеийн байдлаар шимтгэлийн орлогын гүйцэтгэл дундажаар 3%-аар давуулан биелсэн байна.

7.4 Сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

Сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг анхан шатны баримтыг үндэслэн хугацаанд нь тооцон олгож иргэд даатгуулагчдад хөнгөн шуурхай үйлчилж ирсэн.

Зардалын гүйцэтгэлийг сан тус бүрээр гарган дүгнэхэд /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	154 215.9	154 877.2	- 661.3	100.4%
2	Тэтгэмжийн даатгалын сан	12 023.6	8 756.9	3 266.7	72.8%

3	ҮОМШӨ даатгалын сан	5 227.7	4 807.7	420.0	91.9%
4	Ажилгүйдлийн даатгалын сан	2 788.1	3 262.4	-474.3	117.0%
Дүн		174 255.3	171 704.2	2 551.1	98.5%

Дүгнэлт: Тайлант үеийн байдлаар сангийн зардлыг батлагдсан төсвөөс нийт 2,6 сая төгрөг буюу 1,5%-аар хэмнэж ажилласан байна.

7.5 Сангийн төвлөрүүлэлт, санхүүжилт

Шимтгэлийн орлогыг хувиарлан НДЕГ-ын санд төвлөрүүлсэн байдал:

- Тэтгэврийн даатгалын санд – 4.6 тэрбум
- Тэтгэмжийн даатгалын санд – 2.9 тэрбум
- ҮОМШӨ даатгалын санд – 8.5 тэрбум

Үүнээс гадна ЭМДЕГ-тай хамтран ажиллах гэрээний дагуу сар бүр ЭМД-ын шимтгэлийн орлогыг хувиарлаж төвлөрүүлж байна. Тайлант хугацааны байдлаар 18.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

НДЕГ-аас авсан санхүүжилт:

- Тэтгэврийн даатгалын санд – 15.2 тэрбум
- Ажилгүйдлийн даатгалын санд – 0.1 тэрбум төгрөг байна.

2023 онд сангийн орлогын төлөвлөгөөг 102.5 хувиар жигд ханган биелүүлж, сангийн зардлыг хуулийн хугацаанд, хуулийн хүрээнд 98.5 хувийн гүйцэтгэлээр олгож, иргэд даатгуулагч нарт үйлчиллээ.

Нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчилан таниулах сургалтуудыг тогтмол хийж, нийгмийн соён гэгээрүүлэх, нийгмийн маркетингийн хүрээнд нийгмийн шаардлагад нийцүүлэн хэлтсийн пэйж хуудсаар дараах нөлөөллийн ажлуудыг хийлээ.

	<i>moo</i>	<i>VEWS</i>	<i>LIKE</i>	<i>COMMENTS</i>	<i>SHARE</i>
Постер	158	831 202	6 472	574	3 228

Богино бичлэг	10	112 163	3 618	50	9
----------------------	-----------	---------	-------	----	---

	<i>тоо</i>	IEWS	LIKE	COMMENTS	SHARE
Лайв	36	-	78 398	553	991
Нийт		943 365	88,488	624	4 228

Аймаг орон нутгаас зохион байгуулж буй нийгэм олон нийтийн ажил, аянуудад манлайлан оролцож, “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллага боллоо.

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС